



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 1/118

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17. 2.1 "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Ерөнхий сайдын 2023 оны 03 тоот албан даалгавар, Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хортон мэрэгчидтэй тэмцэх ажлын хүрээнд нийлүүлэгдэх шувууны үүр, суултуур, бактерийн бэлдмэл, Мал хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх нарийн өвс, ногоон өвс, тэжээлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттогтох (Байгаль орчин, ХААТ-ийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын нягтлан бодогч)

Б.Сармандах (ЖДҮ хариуцсан мэргэжилтэн)

2.Төслийн хүрээнд нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүн, өвс, тэжээл техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлэгдэж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагад нийцсэн бараа хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, бүрдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ